

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234714

АНГЛИ-МОНГОЛ АВИАЛБАРЫН ЗАРИМ НЭР
ТОМЬЁОГ ОНООХ АСУУДАЛД

Б.Нямжав
С.Батхишиг

Түлхүүр үг: харьцуулсан судалгаа, англи, монгол, авиа зүй, нэр томьёо

Оршил

Тодорхой шинжлэх ухааны академик бичлэгт тухайн салбар ухааны нэр томьёо, түүнд холбогдох онолын ойлголт хамгийн чухал бөгөөд эн тэргүүний судлагдахуун байдаг. Нэр томьёо нь тухайн салбар шинжлэх ухааны ололт, шинэ мэдлэг, үр дүн зэргээс шалтгаалж өргөжин баяжиж байдаг. Тиймээс магистр, докторын ажлын сэдэв, шинэлэг судалгаа бүрээр шинэ нэр томьёог оноох, түүнд хамаарах ойлголтыг тодорхойлох шаардлага гарч болно. Энэхүү өгүүлэлд “Англи-монгол хэлний авиалбарын зэрэгцүүлсэн судалгаа” сэдэвт ажлын хүрээнд нэгдүгээрт, англи хэлний авиалбар зүйн асуудалд холбогдох боловч монгол хэлэнд байдаггүй үзэгдлийн нэр томьёо, хоёрдугаарт, монгол хэлээрх хэл шинжлэлийн нэр томьёоны толь бичгүүдэд зөрөөтэй нэрлэсэн нэр томьёог хэрхэн оноох тухай асуудалд зарим тодорхой хариулт өгөхөөр зорьсон юм.

Хэл шинжлэлийн нэр томьёоны толь бичиг, тайлбар толь, мөн сургалт-судалгааны ном бүтээлд авиалбарын нэр томьёог оноосоор иржээ. Үүнд, А.Лувсандэндэв (1957) “Хэл шинжлэлийн нэр томьёоны монгол-орос, орос-монгол толь”; Д.Төмөртогтоо (2004) “Хэл шинжлэлийн нэр томьёоны хураангуй толь”; Ч.Зэнямбуу, М.Базаррагчаа (2014) “Хэл шинжлэлийн нэр томьёоны тайлбар толь”; Д.Төмөртогтоо нар (2016) “Хэл шинжилэлийн монгол-англи толь” зэрэг толь бичгээс гадна Д.Уртнасан нар (2022) *Авиа зүй, Монгол хэл судлал*. VIII ботийн хавсралтад авиалбар зүйн нэр томьёог оноожээ.

Мөн нэр томьёо оноох, орчуулах онол, арга зүйн талаар О.Адьяа (2000) “Орос, монгол нэр томьёоны бүтэц-утга зүйн харьцуулсан судалгаа”; О.Адьяа (2014) “Монгол нэр томьёо оноож ирсэн гол гол зарчим”; Г.Гэрэлмаа (2020) “Монгол хэлний нэр томьёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж”; Н.Мөнхцэцэг (2020) “Нэр томьёоны орчуулга судлал”; О.Шинэбаяр нар (2020) “Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томьёо” зэрэг бүтээл хэвлэгджээ.

Дурдсан сэдвийн хүрээнд англи хэлний авиалбарын хувьсалд холбогдох нэр томьёог түүвэрлэн монгол хэлээрх толь бичиг, судалгааны бүтээлд оноосон эсэх, оноосон бол толь бичиг бүрд хэрхэн оноосныг зэрэгцүүлэн авч үзэв¹. Ерөнхийдөө өмнөх толь бичгүүдэд ижил үгээр тогтоож тэр нь сургалт-судалгаанд хэвшин тогтсон бол тэдгээр нэр томьёог баримтлах нь зүйтэй гэж үзэв. Мөн Д.Уртнасан нар (2022) *Авиа зүй*, Монгол хэл судлал. VIII ботид тогтоосон нэр томьёог авиа зүй, авиалбар зүйн онолын судалгаанд тулгуурлан оноосон тул даган баримтлав. Харин түүвэрлэсэн нэр томьёоноос англи хэлний авиалбарын үзэгдэлд хамаарах бөгөөд монгол хэлээр орчуулаагүй нэр томьёог, мөн монгол хэлээр ерөнхийлөн орчуулсан юм уу, өмнөх судалгаанд зөрөөтэй оноосон нэр томьёог онолын тодорхойлолтоор дэлгэрүүлэн жишээ баримтаар тайлбарлан оноов. Ингэхдээ олон улсад нэр томьёо боловсруулах арга зүйн үүднээс дараах 10 зарчмыг харгалзан үзэх хэрэгтэй гэснийг үндсэн зарчим болгов. Үүнд:

1. Нэр томьёо нь тогтолцоотой байх
2. Шинжлэх ухааны тодорхой салбарт үйлчилдэг байх
3. Нэр томьёо нь ухагдахуунаа оновчтой илэрхийлдэг байх
4. Нэр томьёо нь ерөнхийдөө нэг утгатай байх
5. Нэр томьёо бүр учир зүйн уялдаа холбоо бүхий шинжлэх ухаанч тодорхойлолттой байх
6. Сэтгэл хөдлөлийн өнгө аясгүй байх
7. Нэр томьёо аль болох товч байх
8. Ойролцоо утгат үггүй байх
9. Тухайн хэлний үг бүтэх үүднээс зөв байх
10. Хос нэр томьёогүй байх (Шинэбаяр нар 2020: 30)

Ингээд англи хэлтэй холбогдох авиалбар зүйн нэр томьёог оноон хэрэглэхдээ дараах дөрвөн хэсэг болгон авч үзлээ. Энэхүү өгүүлэлд нэр томьёо тус бүрийг тусгайлан дурдах боломжгүй тул хэсэг тус бүрд цөөн жишээг тодорхойлов.

1. Англи хэлний авиалбар зүйн онцлогийг илэрхийлэх зарим нэр томьёо

Юун түрүүн, шинжлэх ухааны нэр томьёог онооход тухайн нэрлэлтийн ухагдахуун буюу онолын ойлголтын тодорхойлолтыг судалгааны ном зохиолоос тоймлон тодорхойлж, монгол хэлэнд орчуулагдсан бол зэрэгцүүлэн дурдаж, жишээ баримтаар дэлгэрүүлэн тайлбарлаж оноов.

1.1. Received Pronunciation (RP) : Британийн англи хэлний акцентад тулгуурлах бөгөөд стандарт дуудлага гэж үздэг. Хоёрдогч хэлийг эзэмшихийн талаас дэлхий даяар англи хэл сурч буй хүмүүст заадаг англи акцент юм. Зарим авиалбар зүйчид орчин цагийн англи хэлний “RP” дуудлагыг өмнөд Британийн стандарт англи хэл болгохыг чухалчилдаг.

Мөн үүнийг “BBC”-ийн англи хэл” ч гэдэг (Philip Carr 2008). Хэдийгээр “BBC”-ийн нэвтрүүлэгчид өнөө үед янз бүрийн акцентаар ярьдаг болсон ч энэ нэр өөрчлөгдөөгүй байна.

¹ “Англи-монгол хэлний авиалбарын зэрэгцүүлсэн судалгаа” ажлын хүрээнд гарч байгаа нэр томьёоноос нэг багцад хамаарч болох цөөн нэр томьёог нэг дор тайлбарлах арга зүйг ашиглав. Ерөнхийдөө энд хуваан авч үзсэн 4 бүлэгт хамаарах авиалбарын янз бүрийн хувьсалд хамаатах нэр томьёо олон бий.

Ерөнхийдөө энэ нь Британийн бүс нутгуудын англи хэлний дундыг баримталсан акцентыг нэрлэсэн нэр юм. Түүний нэр хүнд нь хэлний бус нийгмийн хүчин зүйлээс шалтгаалж байна. “RP” нь бусад нийгмийн дээгүүр боловсролтой бүлэгтэй холбогдох хандлагатай байдаг бөгөөд англи хэлийг гадаад хүмүүст заах дуудлагын хэм хэмжээ болдог гол акцент юм (David Crystal 2008).

Энэ Британийн англи хэлний акцент нь Англид хамгийн ойлгогдохуйц дуудлага байсны дээр бүс нутаг судлалын үүднээс ч шүүмж дагуулахааргүй дуудлага учир “BBC” өөрийн нэвтрүүлэгчдээ анх ашиглажээ. Түүнээс хойш “BBC-ийн англи хэл” гэдэг нэр томъёо бий болсон байна. Үүнийг Монголд гарсан толь бичгүүдээс Д.Энхбат (2003) “нийтлэг (заншсан) дуудлага” гэсэн байна. Бид дараах нэр томъёогоор оноох саналтай байна.

Оноолт: “BBC”-ийн англи хэл

1.2. initial consonant (in the initial cluster) болон **pre-initial** (in the initial cluster): Уртнасан нар (2022) Улаанбаатарын аялгуунд үеийн эцэст гийгүүлэгчийн бөөгнөрөл (cluster) бий болсон тухай тодорхойлж түүний хэлбэрүүдийг бүртгэн гаргасан байна. Харин монгол хэлэнд үеийн эхэнд гийгүүлэгчийн бөөгнөрөл байдаггүй. Тэгвэл англи хэлэнд үеийн эхэн, төгсгөлд аль алинд ийм тогтолцоо байх бөгөөд тэрхүү гийгүүлэгчийн бөөгнөрөл нь тогтсон бүтэцтэй байна. Тэр бүтцийн эхний, хоёр дахь, гурав дахь дараалсан гийгүүлэгч нь тусгай нэр томъёотой ажээ. Үүнийг сургалт судалгаа, хэл эзэмшихүй, хэрэглээнд тайлбарлах оноох шаардлага гарч байна. Гийгүүлэгчийн бөөгнөрлийн “*initial consonant*” нь үгийн эхний гийгүүлэгчийн бөөгнөрлийн хоёр дахь гийгүүлэгчийг заана. Жишээ нь: *sting* /stɪŋ/, *sway* /sweɪ/, *smoke* /sməʊk/ зэрэг үгийн “t”, “w”, “m” гийгүүлэгч юм. Харин *pre-initial* (in the initial cluster) гийгүүлэгч нь үгийн эхний гийгүүлэгчийн бөөгнөрлийн эхний гийгүүлэгч байна. Жишээ нь: *sting* /stɪŋ/, *sway* /sweɪ/, *smoke* /sməʊk/ зэрэг үгийн “s” гийгүүлэгч юм. Үүнийг “үгийн эхний давхар гийгүүлэгчийн эхний гийгүүлэгч” (*pre-initial in the initial cluster*), “үгийн эхний давхар гийгүүлэгчийн хоёр дахь гийгүүлэгч” (*initial consonant in the initial cluster*) гэж тайлбарласан үгээр оноож цаашид товчилж томъёолсон ‘C¹C²IC’ (consonant1 consonant2 initial cluster) томъёог хэрэглэх нь тохиромжтой гэж үзэж байна. Үүнтэй адил үеийн төгсгөлийн гийгүүлэгчийн бөөгнөрөл (coda cluster)-ийг ч

pre-final + post-final:	belt
pre-final + final + post-final:	banks

гэж томъёолсныг

‘C¹C²CC’ (consonant1 consonant2 coda cluster);
‘C¹C²C³CC’ (consonant1 consonant2 consonant3 coda cluster)

гэх нь хэрэглээнд ойлгомжтой бөгөөд хялбар байна.

Оноолт: ‘C¹C²IC’ (consonant1 consonant2 initial cluster)
‘C¹C²CC’ (consonant1 consonant2 coda cluster)

2. Хэл шинжлэлийн толь бичгүүдэд зөрөөтэй оноосон нэр томьёо

Зарим нэр томьёог толь бичгүүд, судалгааны зохиолд зөрөөтэй орчуулсан байдаг. Үүнийг англи хэлний авиалбарын асуудлын хүрээнд хэрхэн илэрхийлэх, монгол хэлний юм уу, өөр бусад хэлний авиалбарын асуудал, хувьслын шалтгаан, жишээ зэргээс хамаарч өөр өөр оноолт болж болох талтай.

2.1. accent : энэхүү нэр томьёог монгол хэлэнд дараах хэдэн хувилбараар буулгасан байна.

Д.Төмөртоогоо (2004) “өргөлт”, М.Базаррагчаа, Зээнямбуу нар (2014) “өргөлт”, Д.Энхбат (2003) “а. өргөлт, б. дуудлага, в. төвлөрөл” гэжээ. Тэгвэл энэ нь мөн “өргөлт” гэж орчуулдаг “stress”-ээс ялгаатай.

Дараах тодорхойлолтуудыг анхаарч үзье.

Хадумод Басманны (2006) ‘accent’ бол гадаад хэлний өвөрмөц дуудлага, төрөлх хэлний өгүүлэх шинжээс шалтгаалсан дуудлага юм гэжээ.

Филип Карр (2008) Британийн хэл шинжлэлчид авиа зүй болон авиалбар зүйн шинжийг харгалзан хэлний төрлүүд болон дуудлагуудыг тодорхойлоход ашигладаг нэр томьёо юм гээд акцент нь авиа, авиалбар зүйн шинжээс гадна үгийн сан болон өгүүлбэр зүйн ялгааг илэрхийлдэг нутгийн аялгуугаас ялгаатай гэжээ.

Англи хэлний акцентын нэг жишээ бол “RP” акцентаас эгшиг гийгүүлэгчийн тогтолцоогоороо ялгаатай дуудлагатай Шотландын англи хэл юм. Америкийн хэл шинжлэлчид *accent* болон *dialect* (нутгийн аялгуу) хоёрын ялгааг төдийлөн гаргахгүй байх хандлагатай байдаг.

Питер Рөүч (2009) энэ үгийг хоёр өөр утгаар хэрэглэдэг гээд (1) дууны өндрийг ашиглан үеийг онцлон дуудахыг хэлж болно. Жишээлбэл, ‘potato’ гэдэг үгийн дунд үеийг нь онцолж товойлгосон шинжтэй байна; (2) дуудах тодорхой хэв маягийг хэлнэ. Жишээлбэл, дүрэм, үгийн сан зэрэг нь яг ижил боловч хэлж байгаа байдал маяг нь Шотланд, Кокни, BBC дуудлага гэх мэт өөр өөр акценттай дуудаж ярьдаг олон англи хэл бий. Тиймээс “акцент” нь нутгийн аялгуунаас өөр юм гэжээ.

Харин Дэвид Кристал (2008) акцент гэдэг нь хүнийг аль бүс нутгийнх болох, нийгмийн ямар гаралтайг тодорхойлж өгдөг дуудлагын шинж чанаруудын цогц нөлөө (cumulative auditory effect) юм гэж тодорхойлжээ. Энэ нь зөвхөн дуудлагад хамаатай болохоос дүрэм, үгийн сантай холбогддог нутгийн аялгуунаас өөр гэдгийг тэрээр онцолжээ. Бүс нутгийн акцент (Regional accents) тухайн улсын хөдөө орон нутаг, хот, мөн ижил хэлээр ярьдаг өөр улс үндэстний бүлгүүд (Америкийн, Австралийн), тухайн хэлэн дэх өөр хэлний акцент, жишээ нь Славян акцент гэх мэт ямар ч орон нутагтай хамааралтай акцент байж болно. Нийгмийн акцент (Social accents) нь яригч этгээдийн соёл боловсролын суурь, түвшинтэй хамаатай. Жишээ нь, англи хэлний хувьд Их Британийн бүс нутгийн хувьд дундыг баримталсан боловсрол, нийгмийн үйлчилгээ, хууль шүүх, BBC зэрэгтэй холбоотой акцент голлох бөгөөд үүнийг “Хатан хааны англи хэл”, “BBC-ийн англи хэл” гэх мэтээр нэрлэдэг. Ийм дуудлагатай хүмүүсийг ямар ч акцентгүй ярьдаг гэж үздэг. Гэхдээ энэ нь бүс нутгийн гарал үүслийг илэрхийлэхгүй ч хувь хүн бүр акценттай байж болно гэж Дэвид Кристал үзжээ.

Өргөлт (stress)-тэй адилаар ярианы урсгалд байгаа тодорхой нэг үг эсвэл үеийг онцлон ялгаруулан товойлгоход “акцент” гэсэн нэр томъёог мөн хэрэглэдэг. Дууны чанга, өндөр, үргэлжлэх өнө зэргээр үе, үг, хэлц, өгүүлбэрийг өргөлттэй хэлдэг. Жишээлбэл, *record* гэсэн үг аль үе дээр үгийн өргөлт авч байгаагаараа үйл, нэр үг болох нь ялгарч байна. Өгүүлбэрийн акцент (sentence accent) аялга (intonation)-ын хувьд чухал ойлголт байдаг. Учир нь өгүүлбэрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, утга санаа, урьдчилсан таамаглах утга илтгэх зэрэгт голлон нөлөөлдөг. Жишээ нь:

a. He was wearing a red “hat”.

‘Тэр улаан “малгай” өмсөж байсан’ гэсэн хариултанд “hat” буюу “малгай” гэсэн үгийг онцлон акцент нэмж хэлж байгаагаас дараах

Was he wearing a red coat?

‘Тэр улаан цув өмсөж байсан уу?’ гэсэн асуултын хариулт байна гэдгийг таамаглан, асуултын ойлголтыг засаж “Үгүй ээ, цув биш малгай” гэж тодруулж хариулж байна гэдгийг ойлгож болохоор байхад харин

b. He was wearing a “red” hat.

‘Тэр “улаан” малгай өмсөж байсан’ гэсэн хариултын “red” буюу “улаан” гэдэг үгийг онцлон өргөж хэлж байгаагаас

Was he wearing a green hat?

‘Тэр ногоон малгай өмсөж байсан уу?’ гэж асуусан асуултын хариулт байна гэдгийг таамаглаж “Үгүй ээ, ногоон биш улаан” гэдгийг онцолж байгааг ойлгож болно.

Өөрөөр хэлбэл, “red”-ийг онцолж байна уу, “hat”-ыг онцолж байна уу гэдгээс шалтгаалж цаад ямар санаа илэрхийлэгдэж байна гэдгийг ялгаж болж байна.

Эндээс “*accent*” нь аялга (intonation), нутгийн аялгуунаас ялгаатай бөгөөд хувь хүний болон бүс нутгийн өөр дуудлагын онцлог болох, мөн акцент нь нэгэнт монгол хэлний үгийн санд нутагшиж болохуйц танигдсан шинжлэх ухааны тодорхой салбарт үйлчилдэг, үндсэн ухагдахуунаа бусад ойролцоо нэр томъёоноос илүү оновчтой илэрхийлж байгаа учир “*акцент*” гэсэн бичлэг дуудлагаар нь хэрэглэх нь зүйтэй гэж үзлээ. Энэ нь мөн нэг утга илэрхийлж байгаа нэр томъёог нэг үгээр оноох үндсэн шаардлагад нийцнэ.

Оноолт: *акцент*

2.2. Ambisyllabic(ity): энэ нэр томъёог Д.Энхбат (2003) “үе холбогч, хос байрлалд байх, завсрын байршилд байх” гэжээ. Нэр томъёоны тодорхойлолт, жишээг авч үзвэл, нэг үгийн хоёр үеийн аль алиных нь бүтцэд хамаарах дундын шинжтэй гийгүүлэгчид хамаатай ойлголт юм (Bruce Hayes 2009). Тэрхүү гийгүүлэгч нь хоёрдмол үүрэгтэй, дундын шинжтэй гийгүүлэгч бөгөөд эхний болон дараагийн “үеийн жин”²-д нөлөөлж байна гэж үзэж болно гэсэн үг юм. Энэ

² Үеийн жинд холбогдох ойлголтыг Д.Уртнасан, Ц.Батдорж, С.Батхишиг нарын *Авиа зүй*, Монгол хэл судлал, 2022 VIII ботиос дэлгэрүүлэн үзнэ үү.

дундын гийгүүлэгч нь эхний үеийн төгсгөл, хоёр дахь үеийн эхлэлийн байранд зэрэг оршдог байна. Жишээ нь, англи хэлний *butter* /'bʌtə/, *camel* /'kæm/, *upper* /'ʌpə/, *Lenny* /'leni/ зэрэг үгийг дурдаж болох аж. Монгол хэлний хамар /хам. mar/ гэдэг үгийн м гийгүүлэгч урт бөгөөд дээрх онолын үүднээс ойролцоо үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс үүнийг “үе дундын гийгүүлэгч” гэж оноох нь илүү оновчтой байна.

Оноолт: үе дундын гийгүүлэгч

3. Ойролцоо хувьслын хэлбэрүүдийг томъёолсон бүлэг нэр томъёо

Авиалбар зүйн үүднээс ойролцоо хувьслын хэлбэрүүдийг тухайлбал, нэг хувьслын явц болон үр дүнг нэрлэсэн юм уу, эсвэл эгшиг гийгүүлэгчээс шалтгаалж оноосон онолын ойлголт бүхий бүлэг үг бий. Жишээ нь, сулрал, сугарал, балархайшил, гээгдэл зэргээр орчуулж хэрэглэсэн байдаг “*elision, reduction, lenition, weakening, dropping, deletion, apocope, coalescence*” зэрэг үгийг тусгайлан авч үзье.

3.1. elision : эгшиг, гийгүүлэгч, бүхэл үе гэх мэт нэг юм уу хэд хэдэн авиа авиалбарын хувьслын тодорхой нөхцөлөөс шалтгаалан хасагдахыг хэлнэ. Ерөнхийдөө ийм төрлийн хувьслын ерөнхий нэр томъёо юм. Жишээ нь, *family* /'fæmɪli/ - /'fæmli/, *him* /hɪm/ - /ɪm/, *first light* /fɜrs laɪt/ гэх мэт. Үүнийг монгол хэл шинжлэлийн нэр томъёоны толь зэрэгт Д.Төмөртоого (2004) “үгийн эцсийн эгшиг гээгдэхүй”, М.Базаррагчаа, Зээнямбуу нар (2014) “эцсийн эгшиг гээгдэхүй”, Д.Энхбат (2003) “эцсийн гийгүүлэгч балархайшил, гийгүүлэгч гээгдэлт”, Д.Уртнасан, Ц.Батдорж, С.Батхишиг нар (2022) “авианы хасагдал: сулрал, сугарал” гэжээ. Энэхүү ерөнхий нэр томъёонд “сулрал, сугарлаас гадна гээгдэл, балархайшил” ч багтаж байна.

Оноолт: хасагдал³

3.2. deletion: үүнийг мөн *elision*-ий оронд ашигладаг. Тиймээс адил нэр томъёогоор оноож болохоор байна. Д.Энхбат (2003) үүнийг а. орхигдуулалт, алгасалт, б. хураалт (гишүүн) гэжээ.

Оноолт: хасагдал

3.3. dropping: энэ нь “h-dropping” (мөн “h-deletion” ч гэдэг) буюу *tell him* → *tellim*, “g-dropping” буюу *singing* → *sinɪŋ* гэх мэтээр ямар гийгүүлэгч сугарч байгаагаар тодорхойлж нэрлэсэн байдаг. Ерөнхийдөө дээрх жишээнүүд нь “*elision*”-ий жишээ ч болдог учраас үүнтэй адил гэж үздэг ч “*dropping*” гэх нэр томъёог эгшигтэй холбож хэрэглэсэн тохиолдол байдаггүй. Монгол хэлэнд

³ Бид энэ өгүүллийг бичихийн урьд “Монголын авиа зүйн нийгэмлэг”-ийн ажлын хүрээнд “Авиалбарын нэр томъёоны хэлэлцүүлэг” зохион байгуулсан юм. Тэрхүү хэлэлцүүлэгт энэ нэр томъёоны тухайд Д.Төмөртоого “гээгдэх” гэдэг нь үгийн эцсээс, “сугарах” гэдэг нь аливаа зүйлийн дотроос байхгүй болохыг хэлнэ; О.Самбуудорж “Энд хамаатай нэр томъёонуудыг сайн ялгахгүй бол будилах магадлалтай”; Р.Сарангэрэл “Ерөнхий нь аль нь вэ? Тусгай нь аль нь вэ гэдгийг ялгах хэрэгтэй”; Ц.Батдорж “Хэл, хэлэхүйн түвшинд *орхилт* гэх үү, *сугарал* гэх үү? орхилт/орхиж хэлэхүй гэж болох мэт”; Ц.Мөнхцэцэг “ерөнхий тусгайгийн харьцаа маш чухал. Ойролцоо бүх нэрийг жагсаан ялгаатай талуудыг нь тус бүр дээр оноон бичих нь зөв”; Г.Баттогтох “хагасармал гэж М.Базаррагчаа багш хэлсэн байдаг. Орхилт гэж бас болох юм” гэх мэт санал хэлснийг чухалчлан судалж нэр томъёо бүрийн тодорхойлолт, жишээг харгалзан оноов.

“гээгдэхүй, гээгдэл, сугаралт, сугарал” гэж буулгажээ. Мөн “dropped /t/”, “dropped /d/” гэх мэтээр энэ нэр томъёог хэрэглэдэг ч үүнд хамаатай бүх жишээ нь мөн л “elision”-ий жишээ болдог. Жишээлбэл, *often* - /ɒfən/, *next door* - /neksdɔː/, *sound familiar* - /saʊnfəˈmiliə/, *grand piano* - /grænpiˈænoʊ/ гэх мэт. Үүнээс үзвэл, уг нэр томъёог үгийн голоос юм уу хоёр үг нийлэхэд дундаас нь сугарч байгаа цөөн хэдхэн гийгүүлэгчийн үзэгдэлтэй холбогдож хэрэглэгдсэн байх бөгөөд зарим эрдэмтэд “elide, delete” гэдэг үгтэй ижил утгаар хэрэглэж болох “drop” гэдэг үгийг хэрэглээнд оруулснаар ийм нэр томъёо үүссэн гэж бид үзэж байна.

Оноолт: *сугарал*

3.4. syncope: үгийн үеийг тэнцүүлэн хэмнэх хувьслаар үгийн дундах эгшиг гээгдэх үзэгдэл бий. “Syncope” гэдэг нь үгийн дундах өргөлтгүй эгшиг гээгдэхийг хэлнэ. Жишээлбэл, англи хэлэнд “family”, “probably”, “chocolate”, “different” зэрэг үгийг [ˈfæmli], [prɒ.bli], [tʃɒk.lət], [dɪf.rənt] гэж дууддаг. Үүнийг Д.Төмөртоогоо (2004) “үгийн дундах авиа гээгдэхүй”, М.Базаррагчаа, Зэнямбуу нар (2014) “сугарал, үгийн дундаас авиа сугарах”, Д.Энхбат (2003) “үгийн дундах авиа гээгдэл” гэжээ.

Оноолт: *үгийн дундах эгшигийн гээгдэл/сугарал*

3.5. “weakening”: авианы аль нэг шинж буурах, балархайшихад хүргэх авиа өөрчлөгдөх үйл явцыг хэлнэ. Бүр сегментийг гээж орхиход ч хүргэдэг сулралын үйл явц юм. Энэ нь ихэвчлэн сул үеийн орчимд эсвэл ижилшил явагдах байранд тохиолддог. Жишээлбэл, өргөлтгүй үеийн эцсийн байр гэх мэт.

Үүнийг дотор нь хоёр ангилж болно (Hadumod Bussmann 2006).

(a) *Гийгүүлэгчийн сулрал* (өөрөөр мөн “lenisization” /lenition/ гэнэ): тухайн гийгүүлэгчийг бүрэн гээх хүртэлх гийгүүлэгчийн хүч суларч байгааг хэлнэ (булчингийн хүч буурах эсвэл дуурхаг шинж нэмэгдэх г.м). Жишээлбэл, латин хэлэнд [p] > [b] > [β] болох хувьслыг *lupus* > OSpan. *lobo* [lobo] > Span. *lobo* [loβo] гэсэн үгийн түүхэн хувьслаас харж болно.

(b) *Эгшигийн сулрал*: энэ нь эгшиг төв рүүгээ хэлэгдэх шинж нэмэгдэж эцэстээ эгшигийг бүрэн гээхэд хүргэхүйцээр өгүүлэх хөдөлгөөн сулрахад хүргэж байгаа бүх үйл явцыг хэлнэ. Жишээлбэл, англи хэлэнд үгийн эцсийн эгшиг гээгдэх тохиолдлууд байна.

OldE. *nama* [nama] > MiddleE. *name* [nɛmɐ] > ModernE. *name* [neim].

Дээрх жишээ нь түүхэн үйл явцад гарч буй хувьсал мэт боловч ийм дуудлага ярианы хэлний түргэн ярианд их тохиолддог.

Харин Филип Карп (2008) “weakening”-ийг “lenition”-тэй ижил утгатай гэж үзээд үүнд мөн “reduction”-ийг ч багтаажээ.

Оноолт: *сулрал*⁴

3.6. “Lenition” (сулрал) нь “fortition” (чангарал)-ын эсрэг хувьсал юм. Дууших эсвэл сувгийн нарийсал, чангарал нь сулрах шинж бүхий гийгүүлэгчийн сулрах үйл явцыг хэлнэ. Дуугүй авианууд дууших нь сулралын нэг жишээ юм.

⁴ Мөн зарим сегментийн гээгдлийг “аросоре” гэнэ.

Өөр нэг жишээ бол дуугүй шүргэх гийгүүлэгч сулран [h] болох үзэгдэл бөгөөд энэ нь олон хэлний хувьсалд тохиолддог. Жишээ нь, латин хэлний *filium* гэх үгийн [f] нь испани хэлэнд *hijo* болж хувьсан ороод улмаар эцэстээ сугарсан байдаг байна (Philip Carr 2008). “Lenition”-ийг тодорхойлоход ихэвчлэн “дууших шатлал” буурах” нь баримт болдог. Харин “дууших шатлал өгсөх” чиглэл рүү бол “fortition” (чангарал)-ыг тодорхойлно. Жишээлбэл, англи хэлний шүд, түүшийн хамжих гийгүүлэгч /t/ авиа төвөнхийн /ʔ/ авиа болж дуудагддаг: I can’t swim in salt water /aɪ kɑ:nʔ swim in sɒlʔ ‘wɔ:tə/.

Энэ хувьслыг Д.Төмөртоого (2004) “сулрал”, Д.Энхбат (2003) “сулрал, цуцрал, авиа зөөлрөл”, Д.Уртнасан, Ц.Батдорж, С.Батхишиг нар (2022) “сулралшил” гэжээ.

Оноолт: *гийгүүлэгчийн сулрал*

3.7. “Reduction”: дээрх авиалбарын хувьсалтай ойролцоо өөр нэг нэр томъёо бол “reduction” юм. Энэ нэр томъёог мөн өгүүлбэр зүйд хэрэглэдэг. Нийлмэл өгүүлбэрийн бүтцийг байж болох хамгийн бага бүтэц болгон багасгаж хураахыг “reduction” гэнэ.

Хадумод Басманн (2006) “reduction” гэдэг нь авиалбар зүйд эгшгийн сугарал (аросоре, syncope) эсвэл гийгүүлэгчийн сулралыг хэлнэ гэжээ.

Үүнийг монгол хэлэнд Д.Төмөртоого (2004) “балархайшил”, М.Базаррагчаа, Зээнямбуу нар (2014) “балархайшил”, Д.Энхбат (2003) “балархайшил” гэсэн бол Д.Уртнасан, Ц.Батдорж, С.Батхишиг нар (2022) “балархайшил, гээгдэл” гэжээ.

Эгшгийн хувьд өргөлтгүй үеийн эгшиг ихэвчлэн сулардаг. Жишээлбэл, personal [ˈpʰɜ:sənəl] гэх үгийн өргөлтгүй үеийн эгшгүүд бүгд балархай байна. Харин personality [ˈpʰɜ:sənælɪti] гэсэн нэр үг үүсэхэд нэгдүгээр үе дээр байсан “гол өргөлт” гурав дугаар үе рүү шилжиж, гол өргөлттэй үеийн эгшиг эхний жишээ шиг /nəl/ гэж балархай дуудагдахгүй, харин /næl/ гэж бүтэн шинжээрээ тодорхой дуудагдаж байна.

Питер Рөүч (2009) ‘photograph’ ˈfəʊtəɡrɑ:f, ‘photography’ fəˈtɒɡrəfi, ‘photographic’ -ˌfəʊtəˈɡræfɪk гэх үгээс балархайшсан эгшгийг тодорхой харж болдог гээд гурван үеийн аль нэг нь өргөлт аваагүй бол эхний үеийн эгшиг нь балархайших бөгөөд энэ нь бүх хэлэнд байгаад байдаггүй, англи хэлний чухал онцлог шинж юм гэжээ.

Балархай эгшгийн өөр нэг хэрэглээ нь авиалбарын хувьслын хялбаршуулах явцад гарч ирэх бөгөөд энэ нь зарим төрлийн дараалсан авианд нөлөөлдөг. Гийгүүлэгчийн бөөгнөрлийн хураагдал (consonant cluster reduction) үүний жишээ юм. Жишээлбэл, clock -ыг /ɡrɒk/ гэж дуудах нь бага насны хүүхдийн хэл ярианд түгээмэл байдаг.

Хэмжээний хувьд “reduction” нь эгшгийн урт богиносхтой холбоотой байна. Энэ нь *хагас урт* болон *богино эгшиг* болох гэсэн хоёр төрөл байна. Жишээ нь, *You are asked to the Dean’s office* гэсэн өгүүлбэрт *are* гэх үгийн өргөлтгүй /ɑ:/-ын араас *asked* гэх өргөлттэй үе ороход *are* нь хэмжээний хувьд богино балархайшилд орж өргөлттэй үеийн /ɑ:/-аас богиноссон авиалбарын хувилбар

⁵ Д.Уртнасан, Ц.Батдорж, С.Батхишиг нарын *Авиа зүй, Монгол хэл судлал*, 2022, VIII ботиос дэлгэрүүлэн үзнэ үү.

/ɑ/ болно. Харин балархайшлын чанар (*qualitative reduction*) нь эгшгийн шинжид гарч буй өөрчлөлттэй холбоотой.

Англи хэлэнд хоёр төрлийн “чанарын” балархайшил байна: *зөөлөн* болон *хатуу*. Жишээлбэл, *ashore* /ə'ʃɔ:/, *enforceable* /ɪn'fɔ:səbl/ гэх мэт ихэнх өргөлтгүй эгшиг балархай эгшиг болдог. Энэ төрлийн балархайшлыг *hard* буюу хатуу балархайшил гэнэ. Өргөлтгүй эгшиг /ɪ/ болж өөрчлөгдөх (жишээ нь *enforceable* /ɪn'fɔ:səbl/, *interested* /'ɪnrəstɪd/, *guided* /'gaɪdɪd/ гэх мэт)-ийг *soft* буюу зөөлөн балархайшил гэнэ. Харин балархайшлын үр дүнд гээгдэхийг бүрэн балархайшил (*complete reduction*) буюу гээгдэл гэнэ. Жишээ нь, *national* /'næʃənəl/, *education* /,edju:'keɪʃn/, *reduction* /rɪ'dʌkʃn/ гэх мэт (А.А.Калита, Л.И.Тараненко 2010).

Оноолт: *балархайшил*

3.8. coalescence⁶: мөн дээр дурдсан сугарлын асуудалд зарим ижилшлийн ойлголт холбогдох тул хольж хэрэглэсэн байх нь бий. Жишээ нь, “coalescence” гэх нэр томьёо юм. Энэ нь үеийн бүтцийг хялбарчилж өгдөг авианы өөрчлөлт юм. Тухайлбал, ГЭ-ЭГ гэсэн үеийн дараалан орох байранд төгсгөл нь хоосон (*empty coda*) үеийн араас эгшгээр эхэлсэн гийгүүлэгчгүй үе орж болно. Ийм бүтцээс хоёр үе нийлж урт юм уу, хос эгшигтэй үеийн цөм үүсгэдэг (Hadumod Bussmann 2006). Угтаа ялгагдахуйц байсан хэлний хоёр нэгж нэгдэхийг хэлнэ. Энэ нь ялангуяа түүхэн хэл шинжлэлд хамаатай нэр томьёо юм. Өөр өөр авиалбар, өөр өөр бүтээвэр нэгдэж болдог шиг нэг авиалбарын хувилбарууд мөн нэгдэж болно. Жишээлбэл, орчин цагийн англи хэлний /z/ авиа нь /z/ болон /j/ авианы нэгдлээс үүссэн. Мөн *occasion*, *measure*, *formation* гэх мэт үгийн төгсгөлийн залгаврыг *-ate* + *-tion* гэсэн бүтээврүүдээс нэгдэн үүссэн гэж дүгнэж болно. Тиймээс үүнийг “бүрэн ижилшил” юм уу, нэгдэл гэнэ. Бүрэн ижилших үед авиа, үе, бүтээвэр нэгдэж үеийн тоо өөрчлөгддөг. Үүнтэй ижил төстэй нэр томьёонд *syncretism*, *merger*, *fusion* and *neutralization* зэрэг багтана. Үүнээс “fusion” нь нэг авиалбарт зарим шинж чанараараа нэгдэх олон янзын хувьслыг хэлдэг. Заримдаа үүнийг “merger” ч гэдэг. Ялангуяа “Бөөмийн авиалбар зүй” (*particle phonology*)-д “fusion” нь хоёр үндсэн нэгж нэгдсэнээр хос эгшгийн механизм үүсэх хувьслыг илэрхийлдэг байна.

Оноолт: *уусал*

4. Товчилсон нэр томьёог авиалбар зүйд ашиглах нь

4.1. Англи хэлээрх Advanced Tongue Root (ATR) болон Retracted Tongue Root (RTR) гэсэн нэр томьёог эгшгийн үүрэг оролцоогоор нь монгол хэлний тохиолдолд эгшиг зохицолтой холбогдуулан “Хэлний урагшлах чиглэл”, “Хэлний хойшлох чиглэл” гэж Уртнасан нар (2022) хэрэглэсэн байдаг. Үүнийг [i]/[ɪ], [u]/[ʊ], [e]/[ɛ], [o]/[ɔ] эгшгийн шинж чанартай холбоотойгоор хэлний авианы бүтэх байр урагш, хойш түлхэгдэж байгаагаар авианы хувьслын асуудлуудад дурдагдах тул англи хэлний нэр томьёог товчилсон хэлбэрээр хэрэглэх нь хэрэглээний ач холбогдолтой байна.

⁶ Үүнийг Д.Төмөртоогоо (2004) “уусан нийлэхүй”, Д.Энхбат (2003) “хоёр талын ижилсэхүй”, Д.Уртнасан, Ц.Батдорж, С.Батхишиг нар (2022) “хэлэхүйн хэмнэлт” гэжээ.

4.2. Нугархай хэлний үзэгдэл болох гийгүүлэгчийн бөөгнөрөл монгол хэлэнд зөвхөн үеийн төгсгөлийн байранд илрэх бөгөөд гийгүүлэгчийн бөөгнөрлийн доторх бүтцийг нэрлэсэн нэр томьёог ч дээрх жишээний адилаар товчилсон нэр томьёогоор хэрэглэх нь илүү хялбар байна. Жишээ нь:

`C<sup>1</sup>C<sup>2</sup>IC` (consonant1 consonant2 initial cluster)
 `C<sup>1</sup>C<sup>2</sup>CC` (consonant1 consonant2 coda cluster)
 `C<sup>1</sup>C<sup>2</sup>C<sup>3</sup>CC` (consonant1 consonant2 consonant3 coda cluster) гэх мэт.

Монгол хэлний түүхэн хэл шинжлэлд ч ийм загварыг ашиглаж байсан уламжлал бий билээ. Жишээ нь: утга ялгах өргөлтөт эгшиг бүхий эртний монгол хэлний бүтцийг VCV (эгшиг + гийгүүлэгч + утга ялгах өргөлтөт эгшиг) гэж сургалт судалгааны ном зохиолд хэрэглэдэг.

Дүгнэлт

1. Авиалбар зүй нь авианы харилцан нөлөөллийн явц болон үр дүнг хэлэлцдэг салбар учир тухайн хэлний үзэгдлийн жишээ баримт, түүний үндэс болсон онолын ойлголтыг зөв ухаарах нь чухал юм. Ялангуяа нэг хэлэнд байдаг хувьсал нөгөө хэлэнд байхгүй бол түүнийг онолын тодорхойлолт, жишээ, баримтаар тодорхойлох нь зайлшгүй юм.

2. Авиалбар зүйд эсрэг эсвэл ялгаатай юм шиг мөртлөө бие биеэсээ хамааралтай, бие биеэ нөхсөн хувьслын явц, үр дүн олон бий. Тэдгээрийг ялган тодорхойлж, холбоо хамаарлыг гаргаж, жишээгээр илэрхийлэх нь хэл эзэмшихүйн хэрэглээнд ач холбогдолтой. Англи хэл нь нугархай хэл учир өргөлт, айзмын төрлөөс хамаарсан авиалбарын хувьслын өргөн хүрээний тайлбарыг хамарч байна. Жишээ нь, primary stress “гол өргөлт”, intonation “аялга”, accent “акцент”, tonic “тоона”, lexical stress “үгийн өргөлт”, morphological stress “бүтээврийн өргөлт”, prosodic morphology “бүтээврийн айзам”, prosodic hierarchy “айзмын шатлал”, contrastive stress “тодосгогч өргөлт”, focalisation “аялгын төвлөрөл” гэх мэт.

3. Олон хэлийг сурах орчин цагийн нийгмийн шаардлага, сонирхлоор гадаад хэлний нэрлэлт орж ирэх нь зайлшгүй бөгөөд уг юмыг илэрхийлж байгаа ойлголт нь монгол хэлэнд байхгүй юм уу, дутмаг утгатай бол нэр томьёог тайлбарлах, өөрийн хэлний дуудлагаар авах нь зохистой. Жишээ нь, англи хэлний жишээг ярихдаа, metaphony “эгшгийн дараалалгүй зохицол”, tone⁷ “тоона”, suprasegment “суперсегмент” гэх мэт.

Ном зүй

Зээнямбуу Ч., Базаррагчаа М (2014). Хэлшинжлэлийн нэр томьёоны тайлбар толь. Улаанбаатар.
 Калита А.А., Тараненко Л.И (2010). A Concise Dictionary of Phonetic Terms. *Словник Фонетичних Термінів*. Національний Технічний Університет України. Київський Політехнічний Інститут.
 Мөнхцэцэг Н (2020). Нэр томьёоны орчуулга судлал. Улаанбаатар.
 Уртнасан Д., Батдорж Ц., Батхишиг С (2022). Авиа зүй, *Монгол хэл судлал*. VIII. Улаанбаатар.
 Төмөртоого Д (2004). Хэлшинжилэлийн нэр томьёоны хураангуй толь. Улаанбаатар.
 Шинэбаяр О., Золжаргал Б (2020). Адилтгалын аргаар бүтсэн монгол нэр томьёо. Улаанбаатар.

⁷ Магадгүй хятад гэх мэт өөр хэлний жишээг ярих үед “хөг” гэсэн нэр томьёог хэрэглэж болно.

- Энхбат Д (2003). Хэл шинжлэлийн англи-орос-монгол толь бичиг. Улаанбаатар.
- Bruce Hayes (2009). Syllabification in English, *Introductory Phonology*. Malden, MA: Blackwell.
- David Crystal (2008). A Dictionary of Linguistics and Phonetics, Blackwell Publishing.
- Hadumod Bussmann (1996). Routledge Dictionary of Language and Linguistics. Routledge.
- John Clark & Collin Yallop (1995). An Introduction to Phonetics and Phonology. Oxford: Blackwell.
- Matthew K. Gordon (2016). Phonological Typology. Oxford Survey in Phonology and Phonetics.
- Peter Roach (2009). English Phonetics and Phonology. Cambridge University Press.
- Philip Carr (2008). A Glossary of Phonology. Edinburgh University Press.
- Stuart C. Poole (1999). An Introduction to Linguistics. Palgrave MacMillan.

Abstract

In the academic record of any scientific discipline, the terminology specific to that field and the theoretical concepts it encompasses are crucial in relevance and priority. This lexicon is continually enriched through scientific achievements, new knowledge, and the outcomes of research endeavors within the domain. Indeed, the necessity to assign new terms in one's language and clarify associated concepts arises particularly as a result of each master's and doctoral thesis work, as well as innovative research works.

The purpose of this article is to consider the terminological issues within the scope of the thesis work "The Comparative Study of English-Mongolian Phonology". Firstly, we address assigning terms to phenomena inherent to English phonology but absent within Mongolian phonological structures. Secondly, we aim to designate terminologies that exist with different names within Mongolian linguistic dictionaries.

In the context of the aforementioned thesis work, we selected the terms related to English phonology and assessed their inclusion in Mongolian dictionaries and their treatment in research. Where these terms were found, we conducted a comparative analysis to understand their respective assignments in Mongolian within each dictionary. As a general practice, if the same terms had consistent definitions across most previous dictionaries and had already been entrenched in teaching and research, we opted to maintain continuity by adhering to those established terms. Additionally, terms established in "Phonetics and Phonology", Volume VIII of "Mongolian Language Studies," authored by Urtnasan et al. (2022), were adopted, given their foundation in empirical research. However, for the terms sampled from the selection, those that belong to English phonological phenomena not translated into Mongolian, as well as terms typically rendered into Mongolian in various ways in previous research, were subjected to theoretical definitions and explanations. Examples were provided to illustrate the application of these terms. Accordingly, phonological terms of the English language were categorized into four parts. It is important to note that it is not feasible to discuss every term in this article; therefore, only some of the key terms were selected, and one to two examples were provided in each section for clarification. By providing such detailed explanations and proposed translations, we aim to ensure clarity and accuracy in the assignment and understanding of scientific terms within the English-Mongolian phonological context.

Keywords: The Comparative Study, English, Mongolian, Phonology, terms.

Талархал

Уг өгүүлийг бичихэд үнэтэй зөвлөгөө өгсөн "Монголын авиа зүйн нийгэмлэг"-ийн хамт олон, уншиж шүүмж бичсэн "Монгол судлал" сэтгүүлийн редакцид талархал илэрхийлье.